



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/280

Улаанбаатар хот

Эмнэлзүйн зөвлөх багийн ажиллах
журам, чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах, эмч, мэргэжилтний ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган ажиллах хүрээнд зөвлөн туслах чиг үүрэг бүхий эмнэлзүйн зөвлөх багийн ажиллах журмыг нэгдүгээр, Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлзүйн зөвлөх багийн гишүүдийн нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т даалгасугай.
3. Эмнэлзүйн зөвлөх багийн урамшууллыг дотоод журмандаа нийцүүлэн олгохыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгийн дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080895

А/280
Эрүүл мэндийн сайдын
2017 оны 07 сарын 17-ны өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Эмнэлзүйн зөвлөх багийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь үндэсний хэмжээнд төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, хүртээмжийг сайжруулах, зөвлөн туслах чиг үүргийг газар дээр нь шуурхай гүйцэтгэх эмнэлзүйн зөвлөх багийн үйл ажиллагааг зохицуулан, ажиллах зарчмыг тодорхойлоход оршино.

1.2. Эрүүл мэндийн яамны дэргэд улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлээр зөвлөх үүрэг бүхий эмнэлзүйн зөвлөх баг, төрөлжсөн мэргэшил болон тусгай эмнэлэг нь тусламж, үйлчилгээний чиглэлүүдээр эмнэлзүйн баг байгуулна.

1.3. Төрөлжсөн мэргэшил болон тусгай эмнэлгийн удирдлага нь эрүүл мэндийн байгууллагын эмнэлзүйн багийн ажиллах журам, урамшууллын тогтолцоо, төлөвлөгөөг эрүүл мэндийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулж, батлан, хэрэгжүүлнэ.

1.4. Эмнэлзүйн зөвлөх баг нь гадаад улс орны тэргүүн туршлага, технологийг судалж, өөрийн оронд нутагшуулан нэвтрүүлэх, эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулахад чиглэсэн санал, санаачилгыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрүүл мэндийн байгууллагад гаргаж, хэрэгжүүлнэ.

1.5. Эмнэлзүйн зөвлөх багийн гишүүд нь зөвхөн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ, оношилгоонд зөвлөн туслах чиг үүрэгтэй бөгөөд хуулийн байгууллагад эмнэлзүйн зөвлөлийн гишүүний нэрийн өмнөөс шинжээч эмчээр ажиллаж, дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй, ашгийн төлөө ямар нэг үйл ажиллагаанд оролцохгүй болно.

Хоёр. Эмнэлзүйн зөвлөх багийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлзүйн зөвлөх багийн ажиллах чиглэлийг Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн удирдлагатай зөвшилцөн тогтооно.

2.2. Эмнэлзүйн зөвлөх багийн гишүүд нь тухайн төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр клиникийн туршлагатай, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эмч нараас

бүрдэх бөгөөд эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний эргэлзээг арилгах, яаралтай шийдвэр гаргах, хамтарсан хагалгаа хийхэд зөвлөн тусална.

2.3. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмнэлзүйн зөвлөх баг, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хэлэлцэн, Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлзүйн зөвлөх багийн гишүүнээс биечлэн болон утсаар, онлайн хэлбэрээр зөвлөгөө авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тушаалаар батлагдсан зөвлөлийн гишүүний утас, имэйл хаягаар нь холбоо барьж хүсэлтээ гаргана.

2.4. Эмнэлзүйн зөвлөх багийн гишүүн тодорхой шалтгааны улмаас зөвлөх чиг үүргээ гүйцэтгэх боломжгүй тохиолдолд харьяалагдах эрүүл мэндийн байгууллагын удирдлагад мэдэгдэнэ. Мэдээлэл авсан эрүүл мэндийн байгууллага тухайн хугацаанд эмнэлзүйн зөвлөхийг орлон ажиллах чадвар бүхий эмчийг томилно.

2.5. Эрүүл мэндийн байгууллага шаардлагатай эмнэлзүйн зөвлөлийн гишүүнтэй холбогдож чадахгүй тохиолдолд тухайн мэргэшлийн чиглэлээр лавлагаа шатны тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын удирдлагатай холбогдоно.

2.6. Эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалын хавсралтад дурдагдаагүй төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр улсын хэмжээнд тухайн лавлагаа шатны тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын эмнэлзүйн багаас туслалцааг хүсч болно.

2.7. Эрүүл мэндийн байгууллага Эрүүл мэндийн яамны эмнэлзүйн зөвлөх багаас зөвлөгөө авсан тохиолдол, үр дүн, зөвлөлийн гишүүний талаарх талархал, гомдлын талаарх мэдээг дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар ирүүлнэ.

2.8. Эрүүл мэндийн яамны эмнэлзүйн зөвлөх багаас туслалцаа хүссэн, зөвлөгөө авсан эрүүл мэндийн байгууллага зөвлөлийн гишүүний ажилласан тохиолдлын хөлсийг 50,000 төгрөгөөр тооцож, өөрийн байгууллагын дотоод журамд нийцүүлэн олгоно.

2.9. Төрөлжсөн мэргэшил, тусгай эмнэлэг нь тусламж, үйлчилгээний чиглэл бүрд 3-5 гишүүнтэй эмнэлзүйн багийг байгуулж, ажиллах журам, гишүүдийн нэрс, ажлын урамшууллыг тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага батална.

2.10. Энэхүү журмын 2.9-д заасан баг нь тухайн мэргэшсэн тусламж, үйлчилгээний тасгаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний явцад хяналт тавих, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжил арга зүйгээр дэмжин зөвлөгөө өгөх, залгамж халааг бэлтгэх үүрэгтэй байх бөгөөд багийн шийдвэрийг өвчний түүхэнд тэмдэглэн баримтжуулна.

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 07 сарын 17-ны өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлзүйн зөвлөх багийн гишүүдийн
ажиллах чиглэл, нэрс**

Эмнэлзүйн зөвлөх багийн ажиллах чиглэл	Зөвлөх багийн гишүүн	Зэрэг, цол
Арьсны өвчин судлал	Б.Хандсүрэн	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны доктор, профессор
Дүрс, оношилгоо, Радиологи	Ц.Эрдэмбилэг	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны доктор
	Д.Гончигсүрэн	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны доктор, профессор
Мэдрэл, харвалт судлал	Ж.Ариунаа	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, клиникийн профессор
Нүд судлал	Ж.Баасанхүү	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны доктор, профессор
Сэтгэцийн эмгэг судлал	О.Ганчулуун	Зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор
	Д.Лянхуа	Тэргүүлэх зэргийн эмч, клиникийн профессор
Эмгэг судлал	Ш.Энхтуяа	Зөвлөх эмч, АУ-ны доктор
Яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ	Ц.Ганбат	Зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор
Хордлогын үеийн тусламж	С.Юндэн	АУ-ны доктор, профессор
Дотрын анагаах судлал		
Зүрх судас судлал	Р.Цэвэлмаа	Зөвлөх зэргийн эмч
	Н.Байгалмаа	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, клиникийн профессор
Уушги судлал	Д.Ичинноров	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны доктор, дэд профессор
Хоол боловсруулах судлал	Н.Бира	АУ-ны доктор
Элэг, цөс судлал	О.Баярмаа	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны доктор, клиникийн профессор
Бөөр судлал	Ж.Энхтуяа	АУ-ны доктор
Үе судлал	Д.Зулгэрэл	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны доктор, профессор
Цус судлал	Н.Оюундэлгэр	Зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор
Мэс заслын тусламж, үйлчилгээ		
Ерөнхий мэс засал /Элэг, цөс, нойр булчирхай, ходоод гэдэс/	О.Сэргэлэн	Зөвлөх зэргийн эмч, АШУ-ны доктор, профессор

Зүрх, судасны мэс засал	Н.Баасанжав	Академич, АШУ-ны доктор, профессор
Цээжний хөндийн мэс засал	О.Ганбат	Зөвлөх зэргийн эмч клиникийн профессор
Мэдрэлийн мэс засал	Б.Батчулуун	Зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор
Бүдүүн, шулуун гэдэсний мэс засал	Б.Баттулга	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, клиникийн профессор
Дотоод шүүрлийн мэс засал	Ц.Ишдорж	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны магистр, профессор
Үений мэс засал	М.Отгонбаяр	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, клиникийн профессор
Бөөр, шээсний замын мэс засал	Д.Нямсүрэн	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны доктор, профессор
Эрүү нүүрний мэс засал	Л.Хэнтий	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны доктор, дэд профессор
Чих, хамар, хоолойн мэс засал	Л.Бямбасүрэн	АУ-ны доктор, профессор
Хавдрын тусламж, үйлчилгээ		
Хавдрын ерөнхий мэс засал	Я.Эрдэнэ-Очир	АУ-ны доктор
Толгой хүзүүний хавдрын мэс засал	Г.Пүрэвдорж	АУ-ны доктор
Элэг, цөс, нойр булчирхайн хавдрын мэс засал	Э.Тайванбаатар	Ахлах зэргийн эмч, АУ-ны магистр
Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал	Э.Амарсанаа	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны доктор, дэд профессор
Хавдрын хими эмчилгээ	Я.Замбалгарав	Ахлах зэргийн эмч
Хөнгөвчлөх эмчилгээ	Ц.Гантуяа	Ахлах зэргийн эмч, клиникийн профессор
Халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээ		
Уушгины сүрьеэ	С.Энхтуяа	Зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор
Уушгины бус эрхтэний сүрьеэ судлал	Ц.Ренцэнмягмар	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны магистр
Халдварт өвчний тусламж, үйлчилгээ	М.Оюунгэрэл	АУ-ны доктор
Хүүхэд судлал		
Хүүхдийн мэс заслын тусламж	Д.Авирмэд	Зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
	Б.Энхравдан	Зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
Хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжил	А.Оюунчимэг	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, Клиникийн профессор
Хүүхдийн эрчимт эмчилгээ	Б.Энхтайван	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, Клиникийн профессор
Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ		
Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн тусламж	Д.Сүхээ	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны магистр, клиникийн профессор
Эх барихын тусламж	С.Хишгээ	Зөвлөх зэргийн эмч, АУ-ны доктор, клиникийн профессор